



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/ЗБН

Чингис хот

Тариаланч, ногоочдын сургалт зөвлөгөөн зохион байгуулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариаланч, ногоочдын сургалт, зөвлөгөөнийг 2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулахад зориулж 3000000 /гурван сая/ төгрөг зарцуулсугай.

2. Сургалт, зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Сургалт, зөвлөгөөнд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, сургалт зөвлөгөөний бэлтгэлийг хангаж, зохион байгуулах ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Энх-Амгалан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дугаар сарын 02 өдрийн 41384
дугаар захирамжийн хавсралт

Зардлын төсөв

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд
1	Цайны завсарлага 2 удаа	Ш	200	1500	300,000
2	Бал дэвтэр хавтас	Ш	100	3000	300,000
3	Өдрийн хоол	Ш	100	11000	1100,000
4	Сургалтын багшийн хөлс 1 цагийн хөлс 100,0	цаг	8	150000	1200,000
5	Ном тараах материал		100	1000	100,000
	ДҮН				3000,000